

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.08

АГУУЛГА

1.	Үнэлгээний аргачлал.....	3
1.1	Үнэлгээний асуулгын бүтэц	3
1.2	Үнэлгээний оноо	3
1.3	Хэрэгжилтийн үнэлгээ	3
2.	Үнэлгээний нэгдсэн дүн	4
3.	Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан	5
4.	Дүгнэлт	19

1. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Монголын хөрөнгийн бирж 2022 оны 6-р сарын 9-ний өдөр үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн болно.

1.1 ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГЫН БҮТЭЦ

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх гэсэн 9 үндсэн үзүүлэлт бүхий нийт 36 асуулгаас бүрдсэн.

1.2 ҮНЭЛГЭЭНИЙ ОНОО

Нийт 36 асуулга тус бүрийн хүрээнд хийгдэх шаардлагатай ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргана.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

1.3 ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 1. "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4		66.7%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	5		83.3%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	Нэгдсэн дүн	72	69		95.8%

Хүснэгт 1-д үзүүлсэн үнэлгээний нэгдсэн дүнгээс харахад "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 95.8% буюу хэвийн засаглалтай гэж үнэлэгдсэн байна.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Хүснэгт 2. "БидиСЕК ҮЦК" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д нэмэлтээр гишүүд ямар тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаарх зохицуулалтыг тусгасан. Нотлох баримт: Хавралт №1 өөрчлөлт оруулан баталхаар төлөвлөж буй ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, т омилох асуудлыг т угсасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт т ай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн ТУЗ нь 2023 оны 02 сарын 19-ний өдөр ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн баталсан. Тус журамд ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг зохицуулсан. Мөн тус өдөр "Залгамж халааны бодлого"-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооны баталсан үлгэрчилсэн бодлогын хүрээнд компанийн онцлогт нийцүүлэн баталсан. Нотлох баримт: Хавсралт №2 Залгамж халааны бодлого	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын т уршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхээр төлөвлөн ажиллаж байна.	2	100%

	оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны т айланд дэлгэрэнгүйгээр т усгаж, цахим хуудсандаа байршуулна.				
4	1.4. Компани нь ТУЗ болон т үүний дэргэдэх хороодын бүт эц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигт эй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, т уршлагад т авигдах шаардлага болон хүйсийн т энцвэрт байдал зэргийг т усгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх зорилтыг нэр дэвшүүлэх хорооны холбогдох баримт бичигт тусгасан. Нотлох баримт: Хавралт №1 өөрчлөлт оруулан баталхаар төлөвлөж буй ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх т омилогдоход чиглүүлэх сургалт ыг зохион байгуулах ажил үүргээ гүйцэт гэхэд шаардлагат ай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, т эдгээрийг шинэчлэх сургалт ад т огт мол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь ТУЗ-ийн 9 гишүүний дийлэнх олонх нь 2006 оноос хойш ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа. Шинээр нэр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийг сонгогдсон өдрөөс эхлэн компанийн холбогдох бүх мэдээлэлтэй танилцах боломжоор хангаж ажилладаг төдийгүй тус гишүүд компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авдаг. 2025 оны жилийн сургалтын хөтөлбөрийг хавсралтын дагуу төлөвлөж байна. Нотлох баримт: Хавсралт №3 ТУЗ-ийн сургалтын хөтөлбөр	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохист ой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулан	2	100%

			ажиллаж, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах, ТУЗ-ийн бичиг хэрэг, хуралдааны бэлтгэлийг хангах, тэмдэглэл хөтлөх, хурлаас гарах шийдвэрийг зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг ажлыг хариуцан ажилладаг. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулан, шинэчилсэн журамд тусгасан болно. <i>Нотлох баримт: Хавралт №1 өөрчлөлт оруулан баталхаар төлөвлөж буй ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</i>		
ДҮН (Авбал зохих оноо-12)				12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ <i>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</i>					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам-д гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байхаар заасан байдаг. Хууль болон журмын хэрэгжилтийг ханган ТУЗ-ийн 9 гишүүний 4-ийг хараат бус гишүүнээр сонгосон. Компанийн үүсгэн байгуулагч ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна. <i>Нотлох баримт: Хавралт №1 өөрчлөлт оруулан баталхаар төлөвлөж буй ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</i>	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудит ын хороо нь үйл ажиллагааны журам аудит ын бодлогын баримт бичигт эй байна. Аудит ын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	2023 оны 02 сарын 19-ны өдөр ТУЗ-өөс ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журмыг баталсан. Аудитын хороо нь одоогоор нийт 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн.	2	100%

	Аудит ын хорооны хуралд компанийн гүйцэт гэх удирдлага болон ажилт нууд гагцхүү т ус хорооны хүсэлт ээр оролцоно.		Аудитын хороо нь ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа, ээлжит бус хурлыг компанийн үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч хуралдуулдаг бөгөөд компанийн санхүүгийн тайлагнал, дотоод аудит, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай зөвлөмжийг хүргэж ажилладаг. Гүйцэтгэх удирдлага болон компанийн ажилтнууд хорооны хүсэлтээр хуралд оролцох зохицуулалтыг шинэчилсэн журамд тусгасан. <i>Нотлох баримт: Хавсралт №9 Хороод томилсон тухай тогтоол</i>		
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигт эй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэт гэх удирдлага гагцхүү хорооны хүсэлт ээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ нь 2023 оны 02 сарын 19-ны өдөр ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журмыг шинэчлэн баталсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Цалин урамшууллын хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралдан компанийн цалин урамшууллын бодлогын оновчтой байдал, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны зөвшөөрлөөр гүйцэтгэх удирдлага болон бусад мэргэжилтнүүд хуралд оролцох зохицуулалтыг шинэчилсэн журамд тусгасан. <i>Нотлох баримт: Хавсралт №4 ТУЗ-ийн Цалин, урамшууллын хороог томилсон тухай шийдвэр, холбогдох хорооны журам</i>	2	100%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь 2023 оны 02 сарын 19-ны өдөр хорооны дүрмээ шинэчлэн баталсан. ТУЗ-ийн дэргэдэх “Нэр дэвшүүлэх хороо”	2	100%

	бодлогын баримт бичигт эй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.		нь Залгамж халааны бодлогын баримт бичигтэй бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Нотлох баримт: Хавсралт №4 ТУЗ-ийн Цалин, урамшууллын хороог томилсон тухай шийдвэр		
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон т үр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, зааварт ай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагат ай мэдлэг, ур чадвар, ажлын т уршлага бүхий бүрэлдэхүүнт эй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын хүрээнд ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болох талаар тусгасан. Одоогийн байдлаар компанийн ТУЗ нь өөрийн дэргэдэх аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хүрээнд холбогдох зөвлөмжүүдийг хангалттай түвшинд өгч байгаа тул бусад чиг үүрэг бүхий хороодыг байгуулах шаардлага төдийлөн үүсээгүй байна.	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-10)				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
<i>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус т айлагнал, мэдээллийн ил т од байдлын үнэн, бүрэн, т энцвэрт байдлыг хангана</i>					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил т од байдал, т айлагналын журмыг бат алж, хэрэгжилт эд нь хяналт т авина.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь 2014 оны 06 сарын 20-ны өдөр “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хавсралтаар баталсан тухай бүр болон заавал мэдээлэх зохицуулалтын хүрээнд холбогдох мэдээллийг МХБ-ийн вэб сайт болон өөрийн вэб сайтаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэдээ нээлттэй мэдээлэн ажиллаж байна. 2022 оны компанийн вэб сайтын шинэчлэлтээр хувьцаа	2	100%

			эзэмшигчдэд зориулсан мэдээллийн хэсгийг байршуулан, холбогдох мэдээллийг нийтлэн ажиллаж байна. Нотлох баримт: https://bdsec.mn/shareholder		
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн цахим хуудсын шинэчлэлтийн хүрээнд хувьцаа эзэмшигчдэд зориулсан мэдээллийн хэсгийг гарган, холбогдох журам, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ил тод байдлыг ханган, сайжруулан ажиллаж байна. Нотлох баримт: https://bdsec.mn/shareholder	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус т айлагнал нь т энцвэртэй, т одорхой, бодит байна. Санхүүгийн бус т айлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн т огт ворт ой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилт ууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь жилийн эцсийн болон улирлын санхүүгийн тайланг НББОУС болон СТОУС-ын дагуу бэлтгэдэг. Мөн жил бүрийн санхүүгийн тайланд Санхүүгийн Зохицуулах Хорооны бүртгэлтэй аудитын компаниар аудит хийлгэж, тайланг МХБ болон өөрийн вэб сайтаар дамжуулан нийтэд мэдээллэдэг. Санхүүгийн бус тайлагналын хувьд 2025 оноос эхлэн БОНЗ-ийн тайланг бэлтгэх бөгөөд компанийн үйл ажиллагааны үр дүн, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил зэрэг агуулгаар мэдээлэл бэлтгэн оруулахаар төлөвлөж ТоС холбоонд элсэн зөвлөгөө аван ажиллаж байна. Нотлох баримт: Хавсралт 5 БОНЗ-ийн тайлан	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-6)				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналт ыг зохист ой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, т эдгээрийн үр дүнтэй байдалд т огт мол хяналт т авина					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь жил бүр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй	2	100%

	ажиллагааны журамд хөндлөнгийн аудит орт ой харьцах, т үүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэт гэх нөхцөл боломжоор хангах т алаар т угаж, хэрэгжилт эд нь хяналт т авина.		аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэх үүргээ биелүүлж ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэх аудитын хорооны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломж болон хараат бус байдлаар ханган ажиллаж байна.		
16	4.2. Хөндлөнгийн аудит ор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудит т ай холбоот ой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн ерөнхий нягтлан бодогч аудитын дүгнэлтийг танилцуулдаг. Аудитын хувьд дүгнэлт болон санхүүгийн үр дүнг цаасаар ирүүлдэг.	1	50%
17	4.3. Дот оод аудит ын т огт олцоо, т үүний бүт эц, зохион байгуулалт , чиг үүрэг, т эдгээрт орсон өөрчлөлт ийн т алаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны т айлан болон цахим хуудсаар олон нийт эд т ухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Компани нь 2008 оны 04 сарын 05 өдөр “Дотоод хяналтын журам”-ыг баталсан бөгөөд энэ онд шинэчлэн батлах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	1	50%
ДҮН (Авбал зохих оноо-6)				4	67%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комглайнсын хяналт ыг зохист ой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, т эдгээрийн үр дүнт эй байдалд т огт мол хяналт т авина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүт эцт эй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн,	Бүрэн хэрэгжүүлсэн.	Аудитын хорооны үйл ажиллагааны журамд заасны дагуу аудитын хороо нь компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянадаг. Харин компанийн удирдлагын зүгээс эрсдэлийг	2	100%

	хараат бус байдалд ТУЗ хяналт т авина.		тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, тодорхой хугацаанд хянах явцад баримтлах удирдамж, бодлогыг тодорхойлон ажилладаг. Нотлох баримт: Хавсралт 11 "Эрсдэлийн сангийн дотоод журам", холбогдох ажлын хэсэг томилсон тухай тогтоол		
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороот ой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй т ооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны т айлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, т ус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давт амжийн т алаар т огт мол т айллагнана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс тухай бүр эрсдэлийг үнэлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Энэ оноос эхлэн тус хорооны бүтэц, хуралдсан давтамж, хэлэлцсэн асуудал, гишүүдийн ирц зэрэг холбогдох мэдээллүүдийг үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, ил тод байдлыг ханган ажиллаж байна.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, т эдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа т айлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компаний зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын дунд "BDSCup" хөл бөмбөгийн тэмцээнийг 15 жилийн турш амжилттай зохион байгуулсан. 2025 оноос эхлэн холбогдох эрсдэлүүдэд үнэлгээ хийн тайлан бэлгэн ажиллаж байна. Нотлох баримт: Хавсралт 5 БОНЗ-ийн тайлан	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналт ын заавар	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн зүгээс үйл ажиллагаагаа хууль тогтоомж, дүрэм журмуудад бүрэн	2	100%

	болон бүт эцт эй байх ба комплайнсын хяналт ын хэрэгжилт ийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт т авина.		нийцүүлэн явуулах, ажил үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн стандарт, мэргэжилтний ёс зүйг төлөвшүүлэх зорилгоор дотоодод дагаж мөрдөх “Зах зээлийг урвуулан ашиглахтай холбогдох журам”, “Ёс зүйн дүрэм”, “Дотоод хяналтын журам” зэрэг баримт бичгүүдийг батлан хэрэгжилтийг ханган ажилладаг. Нотлох баримт: Хавсралт №10 Зах зээлийг урвуулан ашиглахтай холбогдох журам Хавсралт №7 Ёс зүйн дүрэм Хавсралт №9 Дотоод хяналтын журам		
ДҮН (Авбал зохих оноо-8)				8	100%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ <i>Эрх бүхий албан т ушаалт ны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт т охирсон, шударга, ил т од байна</i>					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давт амжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил т од хэлэлцэж бат ална.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг ил тод хэлэлцэн баталдаг. Нотлох баримт: Хавсралт №6 ТУЗ-ийн цалин урамшуулал батлах тухай тогтоол	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг т огт оох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэт гэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт ад т усгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь 2022 оноос эхлэн ажилчдыг ажилласан үр дүнгээс нь шалтгаалан үнэлгээ хийж карьер тодорхойлох “Карьер урамшууллын” шинэ системийг нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү системийн хүрээнд албан тушаалд тэнцэх шалгуур, цалин урамшууллын хувь хэмжээг шинэчлэн баталсан. Нотлох баримт: Хавсралт 12 Албан тушаал, ажилласан жилийн урамшуулалбаримт бичиг	2	100%

24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны т айланд гүйцэт гэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэт гэлийн шалгуурыг т угсана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын талаар нийтэд мэдээлэхдээ тухай бүр өөрөөс нь зөвшөөрөл авах тухай тусгасан байдаг. Нотлох баримт: Хавсралт №1 ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-6)				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч т алуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс бат алсан бусад оролцогч т алуудт ай харилцах, хамт ран ажиллах т алаар бодлогын баримт бичигт эй байна. ТУЗ болон гүйцэт гэх удирдлага нь оролцогч т алуудын эрх ашгийг хүндэт гэн, т эдэнт эй хамт ран ажиллах байгууллагын соёлыг т өлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Байгууллагын “Дотоод хяналтын журам” болон “Мэргэжилтний ёс зүйн дүрэм”-д оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, хамтран ажиллах, зөрчигдсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан байдаг бөгөөд хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилладаг. Нотлох баримт: Хавсралт №7 Ёс зүйн дүрэм Хавсралт №9 Дотоод хяналтын журам	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны т айланд оролцогч т алуудт ай хамт ран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар ст рат еги баримт лан хэрхэн хэрэгжүүлж ажилласан т алаар т угсана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан мэдээ, мэдээлэл, оролцогч талуудад хамаарах санхүүгийн бус мэдээллийг нарийвчлан тусгаж, ил тод байдлыг хангаж ажилладаг.	2	100%
27	7.3. Оролцогч т алуудт ай хамт ран ажиллах, мэдээлэл	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн цахим хуудсанд хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд зориулсан “Хувьцаа	2	100%

	<i>солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>		эзэмшигчдэд”, “Захиалга өгөх” гэх мэт булан байдаг бөгөөд үүгээрээ дамжуулан оролцогч талуудад компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг харах, үйлчилгээ авах боломжийг олгодог.		
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дот оод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дот оод журам, ажлын т өлөвлөгөөтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн ажилтнуудын санал хүсэлт өгөх, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх асуудлыг “Дотоод хяналтын журам”-аар зохицуулдаг. 2022 онд “Карьер урамшууллын систем”-ийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд ажилтнуудын мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой шалгууруудыг тусгасан байдаг. Нотлох баримт: Хавсралт №7 Ёс зүйн дүрэм, Хавсралт №8 Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-8)				8	100%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ <i>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг т огт оож, өөрсдөө манлайлан гүйцэт гэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</i>					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой т одорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт т авина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	“Арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүдийн ёс зүйн дүрэм” болон компанийн дотоод “Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм”-д заасны дагуу ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулан ажилладаг. Нотлох баримт: Хавсралт №7 Ёс зүйн дүрэм Хавсралт №8 Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	“Арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүдийн ёс зүйн дүрэм” болон “Дотоод хяналтын журам”-ын дагуу холбогдох асуудлыг хянан ажилладаг.	1	50%

	<i>үлээгчийн” т огт олцоот ой байна.</i>		Цаашид “шүгэл үлээгчийн тогтолцоо”-г нэвтрүүлэх тал дээр анхааран ажиллах болно.		
31	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл т үүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” т огт олцоот ой байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	“Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм” болон компанийн “Дотоод хяналтын журам”-д ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар тусгасан байдаг. Нотлох баримт: Хавсралт №9 Дотоод хяналтын журам Хавсралт №8 Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-б)				5	83%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэт гэн т эгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	<i>9.1. Компани оролцогч т алуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүт эц, зохион байгуулалт , гүйцэт гэлийн үр дүнгийн т алаарх мэдээллийг цахим хуудсаараа т ухай бүр хүргэнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг ханган оролцогч талуудад хүргэх хугацаат мэдээллүүдийг МХБ болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлдэг. Нотлох баримт: Хавсралт №10 Мэдээллийн ил тод байдал тайлагналын журам https://bdsec.mn/shareholder	2	100%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидт ай харилцах хөт өлбөрт эй байх ба т эдэнт эй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, брокерын үйл ажиллагаа эрхэлдэг тул харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэдээ бусад компанитай харьцуулахад илүү хүрч ажилладаг. “Мэдээллийн үйл ажиллагааны” журамд заасны дагуу цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа компанийн тухай мэдээ мэдээллийг хүргэдэг бөгөөд хөрөнгө оруулагчдын санал	2	100%

			хүсэлтийг www.bdsec.mn цахим хуудас, info@bdsec.mn , BDSec JSC facebook хуудсуудаар дамжуулан хүлээн авч шийдвэрлэдэг. <i>Нотлох баримт:</i> <i>Хавсралт №10 Мэдээллийн ил тод байдал тайлагналын журам</i> https://bdsec.mn/shareholder		
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын зохицуулалтын дагуу холбогдох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох материалын жагсаалт, хуралд ирж оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн онлайнаар оролцох, санал өгөх, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	2	100%
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүт цийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компани үйл ажиллагааны чиглэл, дүрмийн өөрчлөлт, нэмж хувьцаа гаргах зэрэг өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлуудыг ХЭХ-р хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оролцох эрхийг бүрэн хангаж ажилладаг.	2	100%
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамт ай байх ба хэрэгжилт ийг нийтэд мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь КТХ-ийн 76.1.17-д заалтаар сонирхлын зөрчилтэй хэлцлийн асуудлыг зохицуулдаг. Мөн компани аливаа сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ тус хуулийн заалтыг, мөн Компанийн дүрмийг баримтлан хэрэгжүүлдэг. Мөн Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг боловсруулсан бөгөөд хэлэлцэн батлахаар төлөвлөж байна. <i>Нотлох баримт: Хавсралт 13 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамын төсөл</i>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-10)				10	100%
НЭГДСЭН ДҮН (Авбал зохих оноо-72)				69	95.8%

4. ДҮГНЭЛТ

"БидиСЕК ҮЦК" ХК нь нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулах, үйл ажиллагаанд холбогдох хууль болон дүрэм журмуудын хэрэгжилтийг хангахыг зорин ажилладаг.

2022 онд шинэчлэгдэн батлагдсан Компанийн Засаглалын Кодексийн маягтын дагуу "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг хоёр дахь удаа үнэлж үзэхэд 95.8% буюу хэвийн засаглалтай гэсэн үр дүнтэй үнэлэгдлээ.

Компанийн шинэчилэн баталсан журмуудын хэрэгжилтийн хүрээнд дахин сайжруулах, ил тод байдлыг хангах тал дээр цаашид анхааран ажиллах болно.